



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/214/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Н.Батчимэг Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
Баянхонгор 2024 оны 02 дугаар сарын 23	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/67
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд ажил хавсарсны нэмэгдэл олгосон, даргын шийдвэргүй бараа материал акталсан нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны

5020250

гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Баян-Овоо сумын Засаг дарга 90.0 хувь, аймгийн Эрүүл мэндийн газраас 80.6 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,147,994.90</u>	<u>51,416,360.62</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,904,525.24	10,415.66
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,904,525.24	10,415.66
3121	Төгрөг	4,904,525.24	10,415.66
31211	Төрийн сангийн харилцах	4,904,525.24	10,415.66
33	АВЛАГА	00.00	9,317,992.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	9,317,992.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,243,469.66	42,087,952.96
351	Түүхий эд материал	5,404,556.42	6,711,299.51
35130	Эм боох материал	5,404,556.42	6,711,299.51
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,195,200.00	00.00
354	Хангамжийн материал	46,643,713.24	35,376,653.45
35410	Бичиг хэргийн материал	1,826,000.00	140,500.00
35420	Аж ахуйн материал	388,100.00	1,231,975.40
35440	Түлш, шатах тослох материал	762,676.99	420,316.00
35460	Хүнсний материал	1,330,089.69	531,917.00
35470	Бусад хангамжийн материал	42,336,846.56	33,051,945.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>718,297,507.62</u>	<u>697,682,493.05</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	718,297,507.62	697,682,493.05
392	Биет хөрөнгө	699,912,840.86	679,413,326.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	659,212,162.00	659,212,162.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,627,423.33	-98,717,244.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,720,000.00	40,720,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,457,865.46	-35,091,865.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	169,068,711.94	191,169,738.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,175,236.82	-110,894,483.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,578,572.65	49,878,572.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,706,080.12	-17,163,552.60
39217	Ном	300,000.00	300,000.00
393	Биет бус хөрөнгө	18,384,666.76	18,269,166.76
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-282,333.24	-397,833.24
39303	Бусад биет бус хөрөнгө	17,512,000.00	17,512,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>776,445,502.52</u>	<u>749,098,853.67</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>776,445,502.52</u>	<u>749,098,853.67</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	776,445,502.52	749,098,853.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	235,794,363.56	235,794,363.56
51101	Өмч: - төрийн	235,794,363.56	235,794,363.56
512	Хуримтлагдсан үр дүн	179,727,862.49	152,381,213.64
51210	Өмнөх үеийн үр дүн	-40,637,178.92	179,727,862.49
51220	Тайлант үеийн үр дүн	220,365,041.41	-27,346,648.85

**Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	360,923,276.47	360,923,276.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>776,445,502.52</u>	<u>749,098,853.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	795,380,463.45	560,192,599.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,698,663.45	21,531,144.40
120	Нийтлэг татварын бус орлого	354,698,663.45	21,531,144.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,779,272.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,589,660.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,189,612.00	00.00
120009	Бусад орлого	00.00	8,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	440,681,800.00	538,661,455.42
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,153,700.00	43,998,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,153,700.00	43,998,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	401,528,100.00	494,663,055.42
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	401,528,100.00	494,663,055.42
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	575,015,422.04	587,539,248.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,015,422.04	587,539,248.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,244,705.32	587,369,301.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,464,947.00	347,425,451.00
210101	Үндсэн цалин	171,112,800.31	221,886,068.31
210102	Нэмэгдэл	100,280,583.94	100,108,514.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,721,620.00	4,347,000.00
210104	Урамшуулал	24,349,942.75	21,083,868.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,594,265.76	44,270,358.00
210201	Тэтгэврийн даатгал	25,957,994.76	30,227,589.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,029,850.00	3,565,328.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,407,079.00	2,852,264.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563,576.00	655,297.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,635,766.00	6,969,880.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,104,697.28	42,278,453.29
210301	Гэрэл, цахилгаан	5,233,987.28	5,549,653.29
210302	Түлш, халаалт	35,178,710.00	35,428,800.00
210303	Цэвэр, бохир ус	692,000.00	1,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,064,545.40	24,199,750.59
210401	Бичиг хэрэг	4,048,900.00	4,397,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,502,225.40	8,381,575.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,030,000.00	1,980,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,983,420.00	7,691,874.60

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	1,748,400.00
2105	Нормативт зардал	70,145,977.79	70,328,128.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,134,857.18	62,295,702.02
210502	Хоол, хүнс	8,341,120.61	8,032,426.69
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,670,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,014,983.60	6,457,219.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	35,492,583.60	2,755,219.60
210604	Урсгал засвар	6,522,400.00	3,702,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,254,000.00	1,992,000.00
210702	Дотоод албан томилолт	2,254,000.00	1,992,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,798,075.00	110,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	699,750.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,625.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,700.00	110,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,000.00	00.00
210807	Газрын төлбөр	100,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,803,213.49	50,307,440.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,654,100.00	3,291,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,149,113.49	47,016,040.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,770,716.72	169,946.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,056,212.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,056,212.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,714,504.72	169,946.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,714,504.72	169,946.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	220,365,041.41	-27,346,648.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	220,365,041.41	-27,346,648.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	605,171,072.00	529,351,803.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,779,272.00	8,340.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,779,272.00	8,340.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,779,272.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,589,660.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,189,612.00	00.00
120009	Бусад орлого	00.00	8,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	551,391,800.00	529,343,463.42

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,710,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,710,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,153,700.00	43,998,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,153,700.00	43,998,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	401,528,100.00	485,345,063.42
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	401,528,100.00	485,345,063.42
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>550,828,702.76</u>	<u>522,833,913.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,828,702.76	522,833,913.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	543,057,986.04	522,663,966.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,014,411.76	340,635,609.00
210101	Үндсэн цалин	167,662,265.07	215,096,226.31
210102	Нэмэгдэл	100,280,583.94	100,108,514.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,721,620.00	4,347,000.00
210104	Урамшуулал	24,349,942.75	21,083,868.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,134,000.00	51,060,200.00
210201	Тэтгэврийн даатгал	25,251,200.00	34,720,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,970,800.00	4,084,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,376,500.00	3,267,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	594,100.00	817,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,941,400.00	8,169,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,939,195.28	42,328,453.29
210301	Гэрэл, цахилгаан	4,723,485.28	5,549,653.29
210302	Түлш, халаалт	30,487,210.00	35,428,800.00
210303	Цэвэр, бохир ус	728,500.00	1,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,230,080.00	15,109,900.00
210401	Бичиг хэрэг	3,509,300.00	1,680,200.00
210402	Тээвэр, шатахуун	10,521,280.00	7,801,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,084,900.00	1,846,900.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,564,600.00	1,965,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	1,816,000.00
2105	Нормативт зардал	52,055,568.00	56,455,954.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,668,293.00	49,221,700.00
210502	Хоол, хүнс	6,877,275.00	7,234,254.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,510,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,750,000.00	5,164,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	166,000.00
210604	Урсгал засвар	5,750,000.00	4,998,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,254,000.00	1,992,000.00
210702	Дотоод албан томилолт	2,254,000.00	1,992,000.00

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,621,131.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,446,906.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	233,600.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	38,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,400.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	591,825.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,059,600.00	9,917,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,059,600.00	9,917,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,770,716.72	169,946.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,056,212.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,056,212.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,714,504.72	169,946.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,714,504.72	169,946.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>54,342,369.24</u>	<u>6,517,890.42</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,437,844.00	11,412,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,437,844.00	11,412,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	49,437,844.00	11,412,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,437,844.00	11,412,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-49,437,844.00</u>	<u>-11,412,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,904,525.24	-4,894,109.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	4,904,525.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,904,525.24	10,415.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-40,637,178.92	00.00	556,080,461.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	-40,637,178.92	00.00	556,080,461.11
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	220,365,041.41	00.00	220,365,041.41
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	179,727,862.49	00.00	776,445,502.52
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	179,727,862.49	00.00	776,445,502.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	179,727,862.49	00.00	776,445,502.52
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,346,648.85	00.00	-27,346,648.85
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	235,794,363.56	360,923,276.47	152,381,213.64	00.00	749,098,853.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	634,129,500.00	534,075,966.29	100,053,533.71	84.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,129,500.00	534,075,966.29	100,053,533.71	84.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,129,500.00	534,075,966.29	100,053,533.71	84.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,263,900.00	340,635,609.00	78,628,291.00	81.2
210101	Үндсэн цалин	233,124,400.00	215,096,226.31	18,028,173.69	92.3
210102	Нэмэгдэл	135,168,000.00	100,108,514.30	35,059,485.70	74.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,347,000.00	4,347,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	46,624,500.00	21,083,868.39	25,540,631.61	45.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,490,200.00	51,060,200.00	1,430,000.00	97.3
210201	Тэтгэврийн даатгал	35,693,300.00	34,720,900.00	972,400.00	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,199,200.00	4,084,800.00	114,400.00	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,359,200.00	3,267,700.00	91,500.00	97.3
210204	Ажилгүйдлийн даатгал	840,000.00	817,100.00	22,900.00	97.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,398,500.00	8,169,700.00	228,800.00	97.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,498,400.00	42,328,453.29	169,946.71	99.6
210301	Гэрэл, цахилгаан	5,869,600.00	5,549,653.29	319,946.71	94.5
210302	Түлш, халаалт	35,428,800.00	35,428,800.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,350,000.00	-150,000.00	112.5
2104	Хангамж, бараа материалын зардал	18,566,400.00	15,109,900.00	3,456,500.00	81.4
210401	Бичиг хэрэг	1,500,300.00	1,680,200.00	-179,900.00	112.0
210402	Тээвэр, шатахуун	11,616,400.00	7,801,300.00	3,815,100.00	67.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,649,700.00	1,846,900.00	-197,200.00	112.0
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00	300,000.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,965,500.00	34,500.00	98.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,816,000.00	-316,000.00	121.1
2105	Нормативт зардал	61,182,200.00	56,455,954.00	4,726,246.00	92.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,281,700.00	49,221,700.00	60,000.00	99.9
210502	Хоол, хүнс	9,400,500.00	7,234,254.00	2,166,246.00	77.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	00.00	2,500,000.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,750,000.00	16,576,000.00	6,174,000.00	72.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	6,000,000.00	3,000,000.00	66.7
210602	Тавилга	7,500,000.00	4,910,000.00	2,590,000.00	65.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.00	166,000.00	584,000.00	22.1
210604	Урсгал засвар	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,992,000.00	8,000.00	99.6
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,992,000.00	8,000.00	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,378,400.00	9,917,850.00	5,460,550.00	64.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,378,400.00	9,917,850.00	5,460,550.00	64.5

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	634,129,500.00	529,351,803.42	104,777,696.58	83.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,998,400.00	43,998,400.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	43,998,400.00	43,998,400.00	0.00	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	585,226,600.00	485,345,063.42	99,881,536.58	82.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	585,226,600.00	485,345,063.42	99,881,536.58	82.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,904,500.00	8,340.00	4,896,160.00	0.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,340.00	8,340.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,904,500.00	00.00	4,904,500.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	4,904,525.24	4,904,525.24	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	10,415.66	10,415.66	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	17.00	5.00	77.3
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	09.00	5.00	64.3
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн сэтгэл, ханамж, итгэл найдварт нийцүүлэн чанар хүртээмжтэй үзүүлэх чиг үүрэгтэй ЭМЯ-ны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд 17 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд тайлант онд нийт 4852 хүнд үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэгийг 820 хүнд, амбулаторийн үзлэгийг 1012 хүнд, гэрийн идэвхтэй хяналтын үзлэгийг 2394 хүнд тус тус хийсэн байна. Эмнэлэгт 284 хүнийг хэвтүүлэн эмчилж, түргэн тусламжийн дуудлагад 219 удаа явж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн байгууллагын ажлын хариуцлага, тусламж үйлчилгээний чанарт сөрөг нөлөө, технологийн зөрчил, хариуцлагагүй байдал, ёс суртахууны доголдлыг гаргахгүй байх”, “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, хүн амын эрүүл мэндийн бодит байдал, хэрэгцээ шаардлагыг хэтийн төлөвтэй уялдуулан давуу талтай ажиллана”, “Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж, тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга С.Отгонжаргал (2023.01.01-2023.03.06, 2023.05.01-2023.12.31), Н.Отгонцэнгэл (2023.03.07-2023.05.01), 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Үлэмжсонин (2023.01.01-2023.12.31) нар зурж, нярваар Б.Пүрэвсүрэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн.
- Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг мөрдөж ажилласан.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол.
- Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 749,098.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 27,346.6 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,904.5	10.4	(4,864.1)
Авлага		9,317.9	9,317.9
Бараа материал	53,243.5	42,088.0	(11,155.5)
Үндсэн хөрөнгө	933,546.3	959,947.3	26,401
Хуримтлагдсан элэгдэл	(215,248.8)	(262,264.7)	(47,015.9)
Нийт хөрөнгө	776,445.5	749,098.9	(27,346.6)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	776,445.5	749,098.9	(27,346.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	776,445.5	749,098.9	(27,346.6)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 10.4 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлээр санхүүжилт олгосонтой холбоотойгоор дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 9,317.9 мянган төгрөг байгаа нь ЭМДС-аас авах санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,088.0 мянган төгрөг болж өмнөх оноос 11,155.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 81,493.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас хандиваар 6,533.8 мянган төгрөгийн бараа материалыг авч, өмч хамгаалах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэрээр 2,730.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж, үйл ажиллагаандаа 96,452.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 959,947.3 мянган төгрөг болж 26,401 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,412.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Баян-Овоо сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Өмч бүртгэх тухай” 12/05 дугаар тогтоолоор 14,989.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 27,346.6 мянган төгрөгөөр буурч 749,098.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 731,894.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 48,682.4 мянга, нийт зарлагыг 780,577.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 173,391.6 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвийг 585,226.6 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 43,998.4 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 585,226.6 мянга, орон нутгийн төсвөөс 43,998.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 485,345.06 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 99,881.5 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон, орон нутгийн 43,998.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 490,249.5 мянган төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 10.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсөв					
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	585,226.6	490,249.5	99,977.1	99.9%
1.1	80302 Нэг иргэнд ноогдох норматив	394,383.5	329,788.9	64,594.6	83.6%
1.2	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	190,843.1	155,556.1	35,287.0	81.5%
1.3	83603 Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	4,904.5	4,904.5	0	100.0%
Орон нутгийн төсөв					
2	71506 Суурин газрын усан хангамж	43,998.4	43,828.5	169.9	99.6%
2.1	80112 Нийтлэг үйлчилгээ	43,998.4	43,828.5	169.9	99.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 35,428.8 мянга, гэрэл цахилгааны зардалд 5,869.6 мянга, цэвэр, бохир усны зардалд 1,200.0 мянга, шатахууны зардалд 11,616.4 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 49,281.7 мянга, хоол хүнсний зардалд 9,400.5 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 2,500.0 мянган төгрөг батлагдаж "Зүүн шанд" ХХК-тай дулаанаар хангах гэрээ, "Ник" ХХК-тай шатахууны гэрээ, "Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-тай

цахилгаан, эрчим хүчээр хангах гэрээ, “Асгамба хайрханы өгөөж” ХХК-тай хоол, хүнс, бараа материал нийлүүлэх гэрээ, ЭМДЕГ-тай эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсөв 802,800.0 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 514,504.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,717.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,402.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 319.9 мянга буюу 5.5 хувь, тээвэр, шатахууны зардлыг 3,815.1 мянга буюу 32.8 хувь, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 60.0 мянга буюу 0.1 хувиар хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 155 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ авах 5 гэрээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 27,317.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 25,620.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1,697.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлж ажиллан биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн удитын газарт даргын 2023 оны 05 дугаар 28-ны өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,697.1	1	1,697.1	100.0%
Зөвлөмж	3	25,620.0	3	25,620.0	100.0%
Нийт дүн	4	27,317.1	4	27,317.1	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,254.4 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 2,523.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 2,730.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 5,254.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 147.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн ажилтанд орон тоонд батлагдаагүй архивын ажлыг хавсарган 2023 онд нийт 2,523.9 төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 2,523.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант онд тус байгууллага нь эм боох материалын дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн 2,730.5 мянган төгрөгийн бараа материалыг даргын тушаалгүйгээр данс бүртгэлээс хасаж акталсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө актлах шийдвэрийг гаргаж зөрчлийг арилгах, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.1. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ авах 4 гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн ажилтанд орон тоонд батлагдаагүй архивын ажлыг хавсарган 2023 онд нийт 2,523.9 төгрөгийн цалин хөлс олгосон байна.	1	2,523.9	1	2,523.9	-	-	-	-
Тайлант онд тус байгууллага нь эм боох материалын дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн 2,730.5 мянган төгрөгийн бараа материалыг даргын тушаалгүйгээр данс бүртгэлээс хасаж акталсан байна.	1	2,730.5	-	-	1	2,730.5		
Дүн	2	5,254.4	1	2,523.9	1	2,730.5	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ авах 4 гэрээг байршуулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 40/А0571121
БНА-2024/214/НА-СТА-ТУЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн ажилтанд орон тоонд батлагдаагүй архивын ажлыг хавсарган 40 хувиар тооцон 2023 онд нийт 2,523,879 төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажил хавсарсны нэмэгдэлд олгосон 2,523,879 (хоёр сая таван зуун хорин гурван мянга найман зуун далан ес) төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч

5050177

нараар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх¹


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт даалгав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 72/А057/МЭ
БНА-2024/214/НА-СТА-ТУС

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ авах 4 гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүлдээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу дулаанаар хангах, шатахуун нийлүүлэх, хүнсний материал нийлүүлэх, анхан шатны тусламж үйлчилгээ авах 4 гэрээг бүрэн байршуулан зөрчлийг арилгаж, биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

5040262


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт даалгав .

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН¹:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



¹ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 79/АОС71121
БНА-2024/214/НА-СТА-ТМЦ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус байгууллага нь эм боох материалын дансанд бүртгэлтэй 16 нэр төрлийн 2,730,484 төгрөгийн бараа материалыг даргын тушаалгүйгээр данс бүртгэлээс хасаж акталсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан

5040285

зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материал акталсан шийдвэрийг гарган зөрчлийг арилгаж биелэлтийг нотлох баримтын хамт 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Отгонжаргал, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт даалгав .

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АУДИТОР:

Н.БАТЧИМЭГ



¹ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно